

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд, аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга (Д.Зоригт)-д үүрэг болгосугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

Гарын үсэг

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах, оролцогч талуудын эрх, чиг үүргийг тодорхойлох, урамшуулал, мэдээллийн сан бүрдүүлэх ашиглах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс (цаашид "Төв комисс" гэх), аймаг (дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс (цаашид "Орон нутгийн комисс" гэх) тус тус ажиллана.

1.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дэргэд Сэтгэцийн өвчний эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комисс, Мэргэжлээс шалтгаалсан өвчний эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комисс (цаашид "Салбар комисс" гэх) ажиллана.

1.4. Төв болон салбар, орон нутгийн комисс нь үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг тус тус мөрдөнө.

1.5. Сэтгэцийн өвчний салбар комисс Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн төв байгууллага, Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар комисс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийг түшиглэн ажиллана.

1.6. Орон нутгийн комисс нь зөвхөн тухайн орон нутгийн харьяа даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэнэ.

1.7. Төв болон салбар, орон нутгийн комисс хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

1.8. Төв болон салбар, орон нутгийн комисс эрх, чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргах ба шийдвэр нь акт, албан шаардлага, дүгнэлт, зөвлөмжийн хэлбэртэй байна.

1.9. Төв болон салбар, орон нутгийн комиссын үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын сангийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

Хоёр. Төв болон салбар, орон нутгийн комиссын бүрэлдэхүүн, тавигдах шаардлага

2.1. Төв комисс нь дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч 6, шинжээч эмч 5, даатгуулагч, ажил олгогчийн төлөөлөл тус бүр 1, нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй байна. Төв комиссын дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч нь орон тооны байна.

2.2. Төв комиссын бүрэлдэхүүнийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, дараах байдлаар томилж, чөлөөлнө. Үүнд:

2.2.1. дарга, нарийн бичгийн даргыг нийгмийн даатгалын төв байгууллагын саналыг үндэслэн;

2.2.2. орон тооны бус шинжээч эмч нарыг энэ дүрмийн 2.13-т заасан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн;

2.2.3. даатгуулагч болон ажил олгогчийн төлөөллийг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой зөвшилцөн.

2.3. Төв комиссын магадлагч эмчийг төв комиссын даргатай зөвшилцөн нийгмийн даатгалын төв байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

2.4. Орон нутгийн комисс нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч 3, нийгмийн халамжийн байгууллагын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5. Орон нутгийн комиссын дарга нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, орлогч дарга нь аймгийн нэгдсэн эмнэлэг (бүсийн оношилгоо эмчилгээний төв), дүүргийн эрүүл мэндийн төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, нарийн бичгийн дарга нь дүн бүртгэлийн эмч, магадлагч эмч нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (хэлтэс)-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус байна.

2.6. Орон нутгийн комиссын хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын саналыг үндэслэн тэдний нэгдмэл эрх ашгийг ханган ажиллахуйц байдлыг харгалзан аймаг, дүүргийн Засаг дарга сонгож, Нийгмийн даатгалын төв байгууллагад санал ирүүлнэ. Нийгмийн даатгалын төв байгууллагын дарга нь Засаг даргын саналыг үндэслэн, төв комиссын даргатай зөвшилцөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг томилж, чөлөөлнө.

2.7. Энэ дүрмийн 2.5-т заасан бүрэлдэхүүний саналыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын төв байгууллагад ирүүлнэ.

2.8. Сэтгэцийн өвчний салбар комисс нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн эмч 4, нийгмийн халамжийн төв байгууллагын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.9. Сэтгэцийн өвчний салбар комиссын дарга нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал, орлогч дарга нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нарийн бичгийн дарга (магадлагч эмч), нарийн бичгийн дарга нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дүн бүртгэлийн эмч, нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь нийгмийн халамжийн төв байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус байна.

2.10. Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар комисс нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн эмч 4, ажил олгогчийн төлөөлөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.11. Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар комиссын дарга нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн газрын дарга, орлогч дарга нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нарийн бичгийн дарга (магадлагч эмч), нарийн бичгийн дарга нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дүн бүртгэлийн эмч тус тус байна.

2.12. Салбар комиссын нийгмийн халамжийн байгууллагын төлөөллийг нийгмийн халамжийн төв байгууллагын, ажил олгогчийн төлөөллийг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан төв байгууллагын санал, төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн нийгмийн даатгалын төв байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

2.13. Төв комиссын (орон тооны бус) шинжээч эмч, салбар комиссын (орон тооны бус) төрөлжсөн мэргэжлийн эмчийг нийгмийн даатгалын төв байгууллага сонгон шалгаруулж, саналаа нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийгмийн даатгалын хэлтэс хамтран сонгон шалгаруулж, саналаа нийгмийн даатгалын төв байгууллагад ирүүлнэ.

2.14. Салбар болон орон нутгийн комиссын бүрэлдэхүүнийг нийгмийн даатгалын төв байгууллагын дарга батална.

2.15. Шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчийг 3 жилээр томилно. Ажлын үр дүнг харгалзан комиссын гишүүнээр ажиллах хугацааг 1 удаа мөн хугацаагаар сунган ажиллуулж болно.

2.16. Шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.16.1. Мэргэжил (мэргэшил)-ээрээ 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй их эмч;

2.16.2. ял шийтгүүлж байгаагүй;

2.16.3. мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй;

2.16.4. багаар ажиллах чадвартай;

2.16.5. нийтийн эрх ашиг, шударга журмыг дээдэлдэг байх зэрэг тус тус болно.

Гурав. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааны хэлбэр, хурлын төрөл, дэг

3.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа нь хурал хэлбэртэй байна.

3.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал нь дараах төрөлтэй байна. Үүнд:

3.2.1. иргэнийг биечлэн оролцуулан;

3.2.2. бичиг баримтанд үндэслэн;

3.2.3. цахимаар;

3.2.4. нүүдлийн.

3.3. Энэ дүрмийн 3.2.1-т заасан хурлыг салбар болон орон нутгийн комиссын эмч нар даатгуулагч (иргэн)-д бодит үзлэг хийн, холбогдох оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнд үндэслэн эрүүл мэндийн байдлыг хэлэлцэн, хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг шийдвэрлэж зохион байгуулна.

3.4. Энэ дүрмийн 3.2.2-т заасан хурлыг даатгуулагч (иргэн)-ийг биечлэн ирүүлэхгүйгээр, тэдгээрийн эрүүл мэндийн байдлыг хэлэлцэн, холбогдох оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнд үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг шийдвэрлэх байдлаар хийнэ.

3.5. Энэ дүрмийн 3.2.3-т заасан хурлыг даатгуулагч (иргэн)-ийг биечлэн ирүүлэхгүйгээр, мэдээлэл, технологийн шийдлийг ашиглан салбар болон орон нутгийн комиссын хурлыг цахимаар зохион байгуулж иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг шийдвэрлэх байдлаар зохион байгуулж хийнэ.

3.6. Энэ дүрмийн 3.2.4-т заасан хурлыг даатгуулагч (иргэн)-д эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор алслагдсан сум, хороонд салбар болон орон нутгийн комиссын хурлыг зохион байгуулж, эмч нар бодит үзлэг хийн, холбогдох оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнд үндэслэн иргэний эрүүл мэндийн байдлыг хэлэлцэн, хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг сунгах, цуцлах шийдвэр гаргаж зохион байгуулна.

3.7. Салбар комиссын хуралд дарга болон орлогч дарга, орон нутгийн комиссын хуралд дарга болон магадлагч эмч нэгэн зэрэг оролцоогүй, төв болон салбар, орон нутгийн комиссын нийт гишүүдийн ирц гуравны хоёрт хүрээгүй тохиолдолд тухайн өдрийн хурлыг хойшлуулна.

3.8. Төв болон салбар, орон нутгийн комисс нь олонхийн саналаар шийдвэр гаргана.

3.9. Төв болон салбар, орон нутгийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд тус бүр саналын эрхтэй байна.

3.10. Салбар болон орон нутгийн комисс нь даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхдээ тус комиссын нарийн бичгийн даргын гаргасан хурлын дарааллыг баримтална.

3.11. Төв болон салбар, орон нутгийн комиссын гишүүд авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, харилцан бие биеэ хүндэтгэж, үндэслэлтэй зөв шийдвэр гаргана.

3.12. Салбар болон орон нутгийн комиссоос гаргасан даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоосон актыг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын програмаас хэвлэж, хуралд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

Дөрөв. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа

4.1. Даатгуулагч (иргэн) нь ердийн болон ахуйн осол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол эмнэлгийн хуудсыг 90-180 хоног хүртэлх хугацаанд авч, эмчийн хяналтад орж, эмчлэгдэн, улмаар эмчилгээний үр дүн, өвчний явц, үе шат, хүндрэл, оношийн баталгаажилт зэргийг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.2. Эрхтэн, бие махбодын тогтоц, үйл ажиллагаа нь хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, байнга хэвтэрт, бусдын асаргаа сувилгаанд байгаа даатгуулагч (иргэн)-д энэхүү дүрмийн 4.1-т заасан хугацаа, эмнэлгийн хуудас авсан эсэхийг үл харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтооно.

4.3. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгааныг ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас гэж тус тус ангилна.

4.4. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг дор дурдсанаар ангилна.Үүнд:

4.4.1. Бүрэн буюу 80-аас дээш хувиар алдсан.

4.4.2. Хагас /хэсэгчилэн/ буюу 79 хүртэл хувиар алдсан.

4.5. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг салбар болон орон нутгийн комисс тогтоох, сунгах, цуцлахдаа эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэнэ.

4.6. Сум орон нутгийн комисстой бол тухайн сумын даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлүүлэх асуудлыг сумын эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч хариуцна.

4.7. Гадаад улсад хорт хавдар, сүрьеэ, эрхтэн шилжүүлэх болон бусад өвчний шалтгаанаар удаан хугацаагаар эмчлүүлж байгаа даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг шийдвэрлэхдээ тухайн улсын эмнэлэгт үзлэг, шинжилгээ, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хамрагдаж буй эсэх талаарх эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь, тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин

сайдын яам эсхүл консулын газрын тодорхойлолт, иргэний хувийн хүсэлт зэргийг үндэслэн салбар болон орон нутгийн комисс шийдвэрлэнэ.

4.8. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг энэхүү дүрмийн 3.2.2, 3.2.3-т заасны дагуу шийдвэрлэж болно.

4.9. Шүүхээр ял эдэлж буй ялтанд хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг зөвхөн хорихын нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн хорих байгууллагын харьяалах орон нутгийн комисс эсхүл салбар комисс шийдвэрлэнэ.

4.10. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

4.10.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг /бүсийн оношилгоо эмчилгээний төв), дүүргийн эрүүл мэндийн төвийн даатгуулагч (иргэн)-ийн хяналтын эсхүл эмчлэгч эмч нь өвчний түүх, бодит үзлэг, оношилгоо шинжилгээний өөрчлөлт, дүгнэлт, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчний онош, өвчний үе шат, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа зэргийг тусгасан үечилсэн дүгнэлтийг үндэслэн гаргасан Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг орон нутгийн комиссын хуралд танилцуулна.

4.10.2. Сэтгэцийн болон хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн төв байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн даатгуулагч (иргэн)-ийн хяналтын эсхүл эмчлэгч эмч нь салбар комиссын хуралд танилцуулна.

4.10.3. Энэ дүрмийн 4.10.1, 4.10.2-т заасан эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг салбар болон орон нутгийн комисст цахимаар болон цаасаар илгээнэ.

4.10.4. Салбар болон орон нутгийн комисс нь эмнэлэг хяналтын комиссоос илгээсэн даатгуулагч (иргэн)-ийн биеийн байдал, шинжилгээ, оношилгоо, онош, өвчний үе шатыг тодорхойлсон бичиг, баримтыг судлан, бодит үзлэг хийж эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэлтэй гэж үзвэл даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг ирүүлсэн саналаар эсхүл өөрчлөн тогтооно.

4.10.5. Салбар болон орон нутгийн комисс нь даатгуулагч (иргэн)-д хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох үндэслэлгүй гэж үзвэл тогтоохгүй. Харин дахин магадлах шаардлагатай гэж үзвэл холбогдох бичиг баримтыг бүрэн бүрдүүлж, үзлэг оношилгоог давтан хийсний дараа тухайн даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

4.10.6. Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэр гараагүй даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг салбар болон орон нутгийн комиссын хурлаар шийдвэрлэхгүй.

4.10.7. Эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны хүнд зэргийн дутагдалтай тээвэрлэх боломжгүй даатгуулагч (иргэн)-ийн хүсэлт, эмчлэгч эмчийн үзлэг дүгнэлтийг үндэслэн салбар болон орон нутгийн комиссын томилсон гишүүн гэрийн үзлэг хийж, саналыг салбар болон орон нутгийн комисст танилцуулан

даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох асуудлыг шийдвэрлэнэ.

4.10.8. Хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг шинээр тогтоохдоо салбар болон орон нутгийн комиссын хурлын шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцно.

4.10.9. Хоёр буюу түүнээс дээш өвчнөөр өвчилсөн даатгуулагч (иргэн)-ийн үндсэн өвчнийг сонгон хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоох ба хавсарсан өвчний үе шат, явц, биеийн ерөнхий байдал зэргийг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын тав хүртэл хувийг нэмж тогтоож болно. Харин үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь дээр ердийн өвчний хувийг нэмж тогтоохгүй.

4.10.10. Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоохдоо энэ дүрмийн 4.10.1 дэх заалтыг баримтлан, эрх бүхий улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн ослын актыг үндэслэнэ.

4.10.11. Хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоохдоо энэ дүрмийн 4.10.2 дахь заалтыг баримтлан, ажил олгогчоос ирүүлсэн хөдөлмөрийн нөхцлийн тодорхойлолтыг үндэслэнэ.

4.11. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгах, цуцлах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

4.11.1. Салбар болон орон нутгийн комисс нь даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгахдаа өмнөх шийдвэрийн хугацаа дуусахаас өмнө эсхүл дууссанаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.11.2. Даатгуулагч (иргэн) хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэхүү дүрмийн 4.11.1-т заасан хугацаанаас хойш 6 сарын дотор салбар болон орон нутгийн комиссын шийдвэрийг сунгуулах бол хүсэлт, хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох баримтад үндэслэн салбар болон орон нутгийн комиссын хурлаар орсон өдрөөс ердийн өвчин бол 2 сараас, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин бол 6 сараас илүүгүй хугацаагаар тус тус нөхөн сунгаж болно.

4.11.3. Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон хувь хугацааг хүчинтэй хугацаанд өвчний хүндрэл, үе шатыг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг дахин магадлан өөрчилж болно.

4.11.4. Даатгуулагч (иргэн) нь хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоосон хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор магадлуулаагүй тохиолдолд даатгуулагч (иргэн), эсхүл асран хамгаалагчид нь мэдэгдэж хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлах шийдвэр гаргана.

4.11.5. Энэхүү дүрмийн 3.2.4-т заасан хурлаар зөвхөн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг сунгах, цуцлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.12. Салбар болон орон нутгийн комисс нь хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах шийдвэр гаргахдаа даатгуулагч (иргэн)-ийн иргэний үнэмлэх, өвчтөний түүх (амбулаторийн карт), холбогдох шинжилгээнд тус тус үндэслэнэ.

4.13. Хөдөлмөрийн чадвараа хугацаагүйгээр алдсан даатгуулагч (иргэн)-ийн эрүүл мэндийн байдал, түүнд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний талаарх судалгааг харьяалагдах өрх болон сумын эмчээс салбар болон орон нутгийн комисс нь хагас, бүтэн жилээр авч, хяналт тавьж ажиллана.

4.14. Даатгуулагч (иргэн)-ийн биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хөдөлмөрийн чадварын бууралт нь цаашид даамжрах төлөвтэй, дадаж мэргэшсэн ажлаа хөдөлмөрийн тогтоосон цагт тоо, чанарын хувьд бүрэн хийж чадахгүйд хүрсэн бол тухайн даатгуулагч (иргэн)-ийг сувилуулах, эмчлүүлэхэд зориулж, ажлын цагийг тодорхой хугацаагаар хорогдуулах шийдвэрийг салбар болон орон нутгийн комисс гаргана.

4.15. Хөдөлмөрийн нөхцөл нь биеийн эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж, өвчин эмгэг нь цаашид даамжран хүндрэх төлөвтэй даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн нөхцлийг эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтын дагуу хөдөлмөрийн нөхцөлийг солих шийдвэрийг салбар болон орон нутгийн комисс гаргана.

Тав. Хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын нийтлэг эрх, үүрэг

5.1. Хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогч талууд болох төв болон салбар, орон нутгийн комисс, эрүүл мэндийн байгууллага дараах нийтлэг эрх, үүрэгтэй. Үүнд:

5.1.1. Эрх:

а/эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаанд алдаа, дутагдал гаргасан, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төв болон салбар, орон нутгийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, албан хаагчдад хариуцлага хүлээлгэх талаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлж шийдвэрлүүлэх;

б/аливаа алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн санг эрсдэлээс хамгаалах чиглэлээр үр дүнтэй ажилласан ажилтныг урамшуулах;

в/төв болон салбар, орон нутгийн комиссын шийдвэрийг алдаагүй, үндэслэлтэй гаргах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг татан оролцуулах.

5.1.2. Үүрэг:

а/авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг даатгуулагч (иргэн)-д шударга, чанартай, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй үзүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах;

б/эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

в/даатгуулагч (иргэн)-ийг хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх, сэргээн засах үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

г/даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас (хэсэгчлэн) алдсан шалтгаан, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох шийдвэр гаргах;

д/даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, шинжилгээ, шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах;

е/төрийн албаны болон нийгмийн даатгалын байгууллагын ажилтны, эмнэлэгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах;

ж/эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг боловсронгуй болгох, тусламж, үйлчилгээг сайжруулах талаар арга хэмжээ авах, санал боловсруулж шийдвэрлүүлэх.

Зургаа. Төв комиссын чиг үүрэг

6.1. Салбар болон орон нутгийн комиссыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, эмнэлэг хөдөлмөр магадлалын тогтолцоог боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

6.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой маргааныг шинжээч эмч болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлтийг, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үзлэг, оношилгоо, шинжилгээний дүнг үндэслэн гомдол гаргагч даатгуулагч (иргэн)-ийг байлцуулан шийдвэрлэх;

6.3. Төв болон салбар, орон нутгийн комиссыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, давтан сургах асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх;

6.4. Салбар болон орон нутгийн комиссын үйл ажиллагаанд шалгалт хийх, гаргасан шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй бол түүнийг өөрчлөх буюу цуцалж буруутай этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээ авахуулах, учирсан хохирлыг төлүүлэх талаар саналыг нийгмийн даатгалын төв байгууллагад хүргүүлэх;

6.5. Орон нутгийн комиссын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төсвийн төлөвлөлтийг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтын талаар тооцоо, судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тогтмол сайжруулах, ашиглах;

6.6. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаа болон түүнд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн зардлын төсвийн төслийг нарийвчилсан хуваарийн саналын хамт хуульд заасан хугацаанд боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

6.7. Мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын үйл ажиллагаа, үр дүн, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, санхүүжилт, төсвийн зарцуулалтад хяналт тавих;

6.8. Энэ дүрмийн 7.8-д заасны дагуу салбар болон орон нутгийн комиссоос ирүүлсэн тайлан, мэдээг улсын хэмжээнд хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэж, тайланг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийх;

6.9. Энэ дүрмийн 6.8-д заасан тайланд хөдөлмөрийн чадвар алдалтын байдлыг улсын хэмжээнд, аймаг, дүүрэг, сум, хороо, тосгоноор ангилан өвчний оношоор бүлэглэн хүн амд харьцуулан тусгаж дүгнэлт гаргах;

6.10. Эрүүл мэндийн байгууллагын байр, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын багаж хэрэгсэл, лаборатори, эм урвалжийг оношилгоо, магадлагаа хийх зорилгоор үнэ төлбөргүй ашиглах.

Долоо. Салбар болон орон нутгийн комиссын чиг үүрэг

7.1. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвараа алдсан шалтгаан, түүний хувь хэмжээг хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн тогтоох;

7.2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үзлэг, оношилгоо, шинжилгээний дүнг үндэслэн эмнэлэг хөдөлмөрийн магадлал хийх;

7.3. Хөдөлмөрийн нөхцөл нь биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, өвчин эмгэг нь даамжран, цаашид хүндрэх төлөвтэй даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн нөхцлийг эхний удаа 6 сар хүртэл хугацаагаар өөрчлөх, шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн нөхцөлийг бүрмөсөн өөрчлөх шийдвэр гаргах;

7.4. Биеийн эрүүл мэндийн байдлын улмаас хөдөлмөрийн чадварын бууралт нь цаашид даамжрах төлөвтэй, тогтоосон хөдөлмөрийн цагт ажлаа бүрэн хийх боломжгүй даатгуулагч (иргэн)-ийн ажлын цагийг богиносгох шийдвэр гаргах;

7.5. Тухайн орон нутгийн хөдөлмөрийн чадвараа алдалтын мэдээллийн цахим санг бүрдүүлж, тогтмол шинэчлэх, хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа хийх, дүгнэлт гаргах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах;

7.6. Орон нутгийн иргэний бүртгэлийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг сар бүр тулган нягтлах, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн санд тогтмол оруулах;

7.7. Гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

7.8. Үйл ажиллагааны хагас жилийн тайлан, мэдээг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлан, мэдээг дараа жилийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор багтаан, үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын төсвийг хуульд заасан хугацаанд боловсруулан төв комисст тус тус хүргүүлэх, тайлан, мэдээний үнэн зөвийг хариуцах;

7.9. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр салбар болон орон нутгийн комиссын хуралд оролцоогүй, салбар болон орон нутгийн комиссын болон эмчлэгч эмчийн эмчилгээ, үйлчилгээний зөвлөмж, зааврыг удаа дараа биелүүлээгүй, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдаагүй, эмчийн хяналтад ороогүй даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгахаас татгалзах, цуцлах шийдвэр гаргах;

Тайлбар: хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт даатгуулагч (иргэн) хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй эсхүл байнга хэвтэрт байдгийн улмаас биечлэн ирж чадахгүй болсныг ойлгох;

7.10. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоохгүй, сунгахгүй ба цуцлах шийдвэр гаргаж, буруутай этгээдээр хохирлыг барагдуулах;

7.11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавих;

7.12. Төв комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай биелүүлэх;

7.13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл нь хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч (иргэн)-ийн эрх ашиг зөрчигдөж байгаа эсэхт хяналт тавьж, төрийн байгууллагын болон иргэдийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр идэвх санаачлага гарган ажиллах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

7.14. Нийгмийн халамжийн төлөөлөл нь даатгуулагч (иргэн)-д нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хамруулах талаар зөвлөлгөө өгөх, сургалт сурталчилгаа хийх, хяналт тавих;

7.15. Даатгуулагч (иргэн)-ийн гаргасан өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, хариу өгөх;

7.16. Салбар болон орон нутгийн комисс нь эрүүл мэндийн байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж, явуулын узель, микрофон, электрон урсдаг дэлгэц, зурагт, цахим зарын самбар ашиглах зэргээр эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг сурталчлах, нээлттэй хүргэх, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

7.17. Салбар болон орон нутгийн комиссын гишүүд нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагаа харилцан солилцож, хамтарч ажиллах;

7.18. Салбар болон орон нутгийн комиссын гишүүн 30 хоногоос дээш хугацаагаар чөлөө авах тохиолдолд энэ тухай 1 сарын өмнө салбар болон орон нутгийн комиссын даргад болон төв комисст урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах;

7.19. Хурлын үед эргэлзээтэй, мэргэжил, арга зүйн зөвлөгөө шаардлагатай магадлал хийх тохиолдол гарсан үед төв комиссын гишүүдээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авах;

7.20. Хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч (иргэн), түүний гэр бүлд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллах.

Найм. Аймаг, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

8.1. Даатгуулагч (иргэн)-ийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

8.2. Орон нутгийн комиссыг үйл ажиллагаа явуулах байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, салбар болон орон нутгийн комиссын гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах талаар шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

8.3. Эрүүл мэндийн байгууллагын менежерийн үр дүнгийн гэрээний шалгуур үзүүлэлтэд хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч (иргэн)-ийг өрхийн болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн идэвхтэй хяналтад оруулах, эмчилгээний үр дүнг тооцох, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг оруулах;

8.4. Орон нутгийн комиссын тайланг жил бүр хэлэлцэж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх.

Ес. Эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг

9.1. Салбар болон орон нутгийн комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

9.2. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацаа тогтоолгож байгаа даатгуулагч (иргэн)-д үйлчлэх тав тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

9.3. Эмнэлгийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж гарсан зөрчлийг арилгаж ажиллах;

9.4. Салбар болон орон нутгийн комиссын хурал зохион байгуулах байр болон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, бусад нөхцөл, боломжоор хангах;

9.5. Тухайн нутаг дэвсгэрийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, нөхцөлийг судлах, шаардлагатай тохиолдолд салбар болон орон нутгийн комисстой хамтран шалгалт хийх, урьдчилан сэргийлэх талаарх судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих;

9.6. Орон нутгийн комиссын магадлагч эмчийг эмчилгээ, оношилгооны удирдамжаар хангаж, холбогдох сургалтад хамруулах, шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллах;

9.7. Эмнэлгийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагааны тайланг улирал тутам орон нутгийн комисст хүргүүлэх;

9.8. Эмчийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтэд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон иргэний эдгэрэлтийн байдалд хяналт тавих үүргийг оруулах;

9.9. Даатгуулагч (иргэн) нь эмчилгээ зөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хяналтын үзлэгт хамрагдаагүй тохиолдолд эмчлэгч эмч хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг бууруулах, цуцлах саналыг салбар болон орон нутгийн комисст гаргах.

Арав. Урамшуулал

10.1. Төв болон салбар, орон нутгийн комиссын дарга, гишүүнд ажилласан цагаар нь тооцож сар бүр урамшуулал олгоно. Урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тооцож Сангийн сайд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

10.2. Орон нутгийн комисс нь хөдөлмөрийн чадварыг сэргээн засах тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлж, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн тоог бууруулахад идэвх санаачлага гаргаж ажилласан, гарч болзошгүй ноцтой алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч ажилласан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн, магадлагч эмч нарт шагнал, урамшуулал олгох тухай саналыг холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлнэ.

10.3. Төв болон орон нутгийн комиссын бүрэлдэхүүнд гурваас дээш жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан магадлагч эмчид 3 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг 3 жил тутамд ажиллаж байгаа байгууллагаас нь олгоно.

10.4. Төв болон салбар, орон нутгийн комиссын бүрэлдэхүүнд тогтвортой ажиллаж байгаа магадлагч эмчийг үндсэн мэргэжлээр нь мэргэжил дээшлүүлэх сургалтад нийгмийн даатгалын байгууллагын зардлаар хамруулж болно.

10.5. Энэ дүрмийн 10.1-10.3-т заасан зардлыг харьяа нийгмийн даатгалын байгууллагын төсөвт тусгана.

Арваннэг.Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн сан

11.1. Төв болон салбар, орон нутгийн комисс нь мэдээллийн нэгдсэн сантай байна.

11.2. Мэдээллийн нэгдсэн сан нь эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, мэдээ гаргах, хяналт шалгалт хийх, бусад цахим үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

11.3. Мэдээллийн нэгдсэн сан дор дурдсан мэдээллийг агуулна:

11.3.1. Төв болон салбар, орон нутгийн комиссоос гаргасан бүх шийдвэр;

11.3.2. Даатгуулагч (иргэн)-ийн:

а/овог нэр, регистрийн дугаар, нас, хүйс, хаяг, харьяалал (аймаг, дүүрэг, сум, баг, хороо, тосгон), холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг, шаардлагатай үед холбоо барих хүний мэдээлэл;

б/хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацаа (онош)-г тогтоосон, сунгасан, цуцалсан, хөдөлмөрийн нөхцөл сольсон, ажлын цаг хорогдуулсан тухай бүх өөрчлөлтийн мэдээлэл;

в/хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоосон, сунгасан, цуцалсан, хөдөлмөрийн нөхцөл сольсон, ажлын цаг хорогдуулсан тухай бүх өөрчлөлтийн шийдвэр гаргасан салбар болон орон нутгийн комиссын гишүүдийн овог нэр, холбоо барих утасны дугаар;

г/хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах тухай бүх өөрчлөлтийн шийдвэрийг салбар болон орон нутгийн комиссын хурлаар шийдвэрлүүлсэн хяналтын болон эмчлэгч эмчийн овог нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар;

д/өвчтөний түүх, амбулаторийн карт, багажийн болон лабораторийн шинжилгээний дүгнэлт;

е/хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулсан хугацаанд ажилласан байдал, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, тусламж, үйлчилгээ, бусад зардал авсан мэдээлэл;

ж/эмчилгээ, сувилгаа хийлгэсэн мэдээлэл.

11.3.3. Эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссоос цахимаар ирүүлсэн шийдвэрийн мэдээлэл;

11.3.4. Шаардлагатай бусад мэдээлэл.

11.4. Даатгуулагч (иргэн) мэдээллийн сангаас өөрийн мэдээллийг авч ашиглаж болно.

11.5. Төв болон салбар, орон нутгийн комиссоос гаргасан бүх шийдвэрийг холбогдох ажилтан, даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулахаар шийдвэрлэсэн шийдвэрийг тухай бүр мэдээллийн нэгдсэн санд комиссын нарийн бичиг дарга нь үнэн зөв оруулна. Бусад мэдээллийг холбогдох байгууллагаас ирүүлнэ.

Арванхоёр. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын хяналт шалгалт

12.1. Төв комисс салбар болон орон нутгийн комиссын үйл ажиллагаа, цахим болон бичиг баримтанд хяналт тавьж ажиллана.

12.2. Төв комисс мэдээллийн санг ашиглан судалгаа үнэлгээ хийсний үндсэн дээр дунджаас дээш эрсдэлтэй салбар болон орон нутгийн комиссын үйл ажиллагаанд жилд 3-аас доошгүй удаа дахин магадлал хийж шалгана.

12.3. Төв комисс мэдээллийн санг ашиглан судалгаа үнэлгээ хийсний үндсэн дээр өндөр эрсдэлтэй салбар болон орон нутгийн комиссын үйл ажиллагаанд төв комиссын шинжээч эмч болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран бүрдмэл магадлалыг жилд 2-оос доошгүй удаа хийж шалгана.

12.4. Мэргэжлийн хяналтын байгууллага нь төв болон салбар, орон нутгийн комиссын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ.

12.5. Эрүүл мэндийн төв байгууллага нь эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

12.6. Орон нутгийн комисс нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагын холбогдох цахим мэдээллийн санг ашиглан даатгуулагч (иргэн)-ийн ажилласан байдал, биеийн байдал, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сувилгаа хийлгэсэнд хяналт тавина.

Арвангурав. Хариуцлага

13.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаанд алдаа, зөрчил гаргасны улмаас даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг үндэслэлгүйгээр тогтоосон бол албан хаагчид холбогдох хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.2. Даатгуулагч (иргэн) хуурамч баримт бичиг үйлдэж хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоолгохыг завдсан, тогтоолгосон бол хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.3. Хяналтын болон эмчлэгч эмч нь хуурамч баримт бичиг үйлдэж хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг даатгуулагч (иргэн)-д тогтоолгохыг завдсан, тогтоолгосон бол хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.4. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоолгох зорилгоор багажийн болон лабораторийн шинжилгээг хуурамчаар үйлдсэн эрүүл мэндийн байгууллагын ажилтанд холбогдох хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Арвандөрөв. Бусад зүйл

14.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон хувь, хугацаанаас үл хамааран өөрийн өвчний байдал, үе шатанд нөлөөлөхгүй ажил, хөдөлмөр эрхэлж болно.

14.2. Энэхүү дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, маягыг нийгмийн даатгалын төв байгууллага баталж болно.

--- оОо ---